



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 4/382

Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, 15 дугаар зүйлийн 15.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.6, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний 04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны XVII дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Энэтхэг Улсын Лакноу хотод зохион байгуулагдах Математикийн Олон улсын олимпиадад Монгол улсаа төлөөлөн оролцох Б.Дэлгэрмөрөнд 1,500,000 төгрөг, Цусны хорт хавдартай иргэн Т.Эрдэнэчулууны эмчилгээний зардалд 350,000 төгрөг, Дэлхийн цусны донорын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэхэд доноруудаа сурталчлах үйл ажиллагаанд 2,000,000 төгрөг, Эрт илрүүлэг үзлэгийг эрчимжүүлэх үйл ажиллагаанд 2,186,360 төгрөгийг, Архангай аймагт болох Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг оролцуулсан улсын аварга шалгаруулах тэмцээний баг тамирчдад 1,500,000 төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2. Дээрх зардлын 7,536,360 (Долоон сая таван зуун гучин зургаан мянга гурван зуун жаран) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-т зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

6712011137
Захирамж 2024